



**ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ**

2022 оны 05 сарын 02 өдөр

Дугаар 8/26

Ховд

Дамдинсүрэнгийн Бямбасүрэнг түр  
орлон гүйцэтгэгчээр томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3, 16.5.5, Төрийн албаны тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.3.3 дахь заалт, Засгийн газрын 2019 оны 9 дүгээр тогтоолоор “Төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэхэд цалин, урамшуулал олгох журам”-ыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчээр Нийгмийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн Дамдинсүрэнгийн Бямбасүрэнг 2022 оны 05 дугаар сарын 02-ны өдрөөс эхлэн томилсугай.

2. Д.Бямбасүрэнд Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн хэлтсийн даргын албан тушаалын цалинг 40 хувиар бодож олгохыг Санхүү, аж ахуйн тасгийн дарга бөгөөд ерөнхий нягтлан бодогч (Б.Нямдэлгэр)-д даалгасугай.

ДАРГА



Д.ЭНХБОЛД

8200 03<sup>Тус</sup> 0432